

ТЭГЭЭД **БҮХ ДЭЛХИЙ МЭДЭХ БОЛНО!**

Есүс Христийн амиллын
2000 жилийн ойг тэмдэглэх нь

ОЛИВЕР ФЛЮРИ

Тэгээд бүх дэлхий мэдэх болно!

Then the world will know

© Зохиогчийн эрх 2015 он Оливер И.Флюри эзэмшинэ.

Анхны хэвлэл Франц хэлээр 2015 онд “Jesus Celebration 2033”

Хавтасны эх дизайн: Жинн Чарлз Рошат

Монгол хэлээр анх хэвлэгдсэн 2025 он.

Эрхлэн гаргасан: YWAM Darkhan Mongolia Хэвлэлийн
Үйлчлэл

Орчуулсан: Пүрэвдоржийн Мөнхцэцэг

Хянасан: Батхуягийн Ариунбилэг

Хавтасны зураг: Отгонтөгсийн Тамир

© Бүх эрх хамгаалагдсан. Энэхүү номын эхийг зохиогчийн бичгэн зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэх, хувилж олшруулах ямар ч хэлбэрээр ашиглахыг хориглоно. Хэвлэмэл шүүмж нийтлэлд богино хэмжээгээр эш татаж болно.

ISBN: 978-2-9701611-3-4

Ариун Библи © 2013 он Ариун Бичээс Библийн нийгэмлэг.

Хэвлэлийн хуудас: 9хх

Хэвлэлийн хэмжээ: А5

“Сэлэнгэпресс” ХХК-д хэвлэв.

АГУУЛГА

Мялаалга	5
Онцгой талархал	13
Өмнөх үг	17
1 Үзэгдэл	19
2 JC2033	
3 Тэмдэглэлт баяруудын Бурхан	
4 100000 ширхэгтэй эвлүүлдэг зураг	
5 Израил дахь баталгаа	
6 Дэлхийн хаалга Африк	
7 Сүүлчийн тив Ази	
8 Ватиканд хүлээн авсан нь	
ХОЁР ТОМ АСУУЛТ...	
Есүс хэзээ амилсан бэ?	
Тэр үнэхээр амилсан: Одоо яах билээ?	
Хүүрнэл	28

М

МЯЛААЛГА

Энэ бол нэрд гарсан 33 Христитгэгчийн мялаалгын үгс. Ватикан, Израил, АНУ, Кени, Шинэ Зеланд, Англи, Египет, Нидерланд, Армен, Австрали, Ливан, Энэтхэг гээд аль ч орон бай тэдний хэлсэн нийтлэг сэдэв нь баяр хөөр, эв нэгдлийг харах хүсэл, хүлээлт юм.

“Энэ бол маш сайхан ажил байна. Маш том ажил! Үүнийг хийж байгаад баярлалаа. Хамт алхаснаар эв нэгдэл ирдэг.”

**Ромын тэргүүн хамба, Пап Францис
Ватикан**

“Амилал бол Христитгэлийн үндэс суурь. Үүнгүйгээр бидний мэдээ хоосон. Бид Амилсан баярыг баяр хөөртэйгээр тэмдэглэдэг. Энэ баяр бол Ортодокс чуулганы хувьд хамгийн чухал баяр, бусад чуулгануудын хувьд ч мөн адил. Амиллын баяр хөөр бидний дунд оршсоор буй бөгөөд бид бүх бүтээлийн хамт үүнийг магтан дуулж байдаг билээ.”

**Константинопл дахь Грек Ортодокс чуулганы
тэргүүн дээд хамба Гэгээн эцэг Бартоломай I
Истанбул, Турк**

“Амилсан баярын 2000 дахь жилийг Христитгэгчид бүгд хамтдаа тэмдэглэх сэтгэл догдлуулсан зөн харааг Оливер Флюри өвлөн авчээ. Би түүний энэ онгод хийгээд зориулалтыг хөхиүлэн дэмжиж, бусад сая сая хүмүүсийн хамтаар дэлхийн түүхэн дэх хамгийн агуу үйл явдал болох Есүсийн амиллыг тэмдэглэхээр нэгдэхийг тэсэн ядан хүлээж байна.”

**Альфа Олон улсын байгууллагын тэргүүн,
Ариун Гурвал сүмийн санваартан Бромптон
Ники Гамбел
Нэгдсэн Вант Улс**

“Ертөнц өөрөө анхлан бүтээгдсэн түүхийг эс тооцвол, Есүс Христийн амилалтай дүйцэхүйц үйл явдал ертөнцийн түүхнээ өөр байхгүй гэж би итгэдэг. Есүсийн амиллын 2000 дахь жилийг тэмдэглэх хараа Эзэнээс өгөгдсөн нь гайхамшигтай бөгөөд хүлээн авч, уухайлан дэмжихээс аргагүй санагдаж байна. Дэлхий даяар энэхүү тэмдэглэлт үйл явдалд бэлтгэхэд Эзэн Өөрийн чуулганы итгэгчдийг хөдөлгөх болтугай.”

**Африк Энтерпрайсыг үндэслэгч, Эвлэрүүлэл
үндэсний хөдөлгөөний эхлүүлэгч Майкл Кассиди
Өмнөд Африк**

“2033 он гэхэд дэлхий даяар 7000 хэлээр Библи хэвлэгдсэн байна гэж Библийн хөдөлгөөнийхөн хэлдэг. Амилсан баярын 2000 дахь жилээр Есүст өгөх ямар гайхалтай бэлэг болох бол? Дэлхийн хаана ч байсан та энэ түүхэн баярын нэг хэсэг нь болоорой.”

**Үүрэгтэй залуус (YWAM)-ыг үндэслэгч
Лорен Каннингхэм
АНУ**

“JC2033 санаачлагын гайхалтай давуу тал бол Есүс Христийн амиллыг тэмдэглэхдээ бид Түүнийг гэрчлэхэд оршиж байгаа юм. Хүн төрөлхтнийг хайрласан Бурхан Эцэгийн хайр, амь өгөгч Ариун Сүнсний хүчийг баярлан тэмдэглэхийн тулд Есүсийн нэр дээр нэгдсэн итгэгчдийн гэрчлэл бол сайнмэдээг үр нөлөөтэй түгээхэд амин чухал зүйл. Хэрвээ бид загалмайг өргөснөөр нэгдмэл болдог юм бол, Амилсан Нэгэний дотор нэгдэж, Ариун Сүнсний хайраар хүчийг олсон биднийг Амилал гэрчлүүлэхээр урагш хөдөлгөх болно.”

**Центро Про Юнион Тереза
Росси Ром, Итали**

“JC2033 бол өнгөрсөн үйл явдлыг тэмдэглэн өнгөрүүлж буй төдий хэрэг биш, харин олон сая хүмүүсийн амьдралд гарах гэнэтийн өөрчлөлтийн эхлэл юм.”

**Дэлхийн чуулгануудын зөвлөл (WCC)-ийн Дэлхийн илгээлт ба Сайнмэдээний захирамж, удирдагч асан
Жосеф Ким
Өмнөд Солонгос**

“JC2033 бол Есүсийг бүх дэлхийд танилцуулах энэ үеийнхний хамгийн агуу боломж байх болно гэж би итгэж байна. Энэ бол урьд хожид байгаагүй ирээдүйн итгэл найдвар.”

**Кампус Крусейд фор Крайст, дэд ерөнхийлөгч
Паул Эшлемэн
АНУ**

“Есүс амилсан, өнөөдөр ч амьд! Тэр өдрөөс хойш дэлхий даяар итгэгчид үүнийг хүчтэйгээр тунхагласаар байгаа. 2033 он хүртэл бид бүр ч илүүгээр тунхаглах болно. Үүнд би маш их баяртай байна.”

**“Дэлхийн Сайнмэдээ тараах Өдөр” санаачлагч
Вернер Нахтигал
Герман**

“Биднийг нэгтгэдэг зүйл бол Есүс Христийн үхэл ба амилал. Тиймээс энэ агуу үйл явдлын 2000 жилийн ойг тэмдэглэж, дэлхий нийтэд Түүнийг мэдүүлэх нь бидний хийж болох хамгийн сайн зүйл мөн!”

**Африк Энтерпрайс, гүйцэтгэх захирал
Стефен Мбого
Кени**

“2033 он бол 2000 оноос илүү чухал, учир нь Христийн амиллаар Христитгэл эхэлдэг. Үүнийг хамтдаа тэмдэглэх боломж чуулганд өгөгджээ.”

**Дэлхийн чуулгануудын зөвлөлийн Константинопл дахь төлөөлөгч, аркбишоп Жоб Гетча
Турк**

“Есүсийг үхлээс амилуулсан Ариун Сүнс үндэстнүүдийн өмнө Түүнийг өргөмжлүүлэхийн тулд энэхүү түүхэн боломжийг барьж авахад нь туслан Өөрийн биед амин амьсгалыг үлээн өгөх болтугай!”

**Суккат Халлел (24/7 магтаал, залбирал)-ыг
үндэслэгч Рик Райдингс
Иерусалим, Израил**

“Түүхэнд хэзээ ч бүдгэрэхгүй цор ганц үйл явдал бол амилал билээ. Би амьдрал, итгэлээ үүн дээр суурилуулж, яруу алдартайгаар дахин ирэх хүртэл нь одоо үүгээр амьдарч байна. Би залбирал болон хамтралаараа баттай зогсох болно.”

**Гэгээн Иосефийн их сургуулийн Теологийн
профессор Сураяа Бичилани
Бейрут, Ливан**

“2033 оны Амилсан баярыг хэн ч өмчилж чадахгүй. Ямар нэг сайхан санааг өөрийн гэж өмчлөх хүмүүс олон байдаг. Гол нь бүгд өөрсдийн хувь нэмрээ нэгтгэж чадах баялаг бөгөөд бүтээлч хөдөлгөөн өрнүүлэх явдал. Тэгвэл Сүнс хөдлөх болно! Бид одоо л эхлэх ёстой. Чуулганууд болон хөдөлгөөнүүдтэй хамтран үүнийг хийхийг бид хүсэж байна.”

**Дэлхийн чуулгануудын зөвлөлийн
ерөнхий нарийн бичгийн даргын онцгой зөвлөх
Мартин Робра
Швейцар**

“Хүн төрөлхтний түүхийн эргэлтийн цэг бол Есүс Христийн амилал. Элч нар загалмайнаас ч илүү амиллыг тунхаглаж байсан. Бидний ойлгодоггүй зүйлийг тэд ойлгосон байх. Амиллын утга учрыг чуулган дахин олж нээх зайлшгүй шаардлагатайг Оливер зөвөөр олж харжээ.”

**Елим чуулганууд, үндэсний удирдагч
Майк Гриффитс
Шинэ Зеланд**

“Христийн нэрд итгэдэг Өөрийн хүүхдүүдийг Бурхан бүх хэлтэн, үндэстэн, итгэлтнүүдээс бэлтгэж байна. Эцэг нэгтэй ах эгч дүүс. Есүсийг төв болгосон эв нэгдэл бий болно. Есүс бол Эзэн бөгөөд Аврагч гэдгийг хамтдаа дэлхийд зарлаж, түүнийг баярлан тэмдэглэнэ. Энэ бол бидний үүрэг даалгавар бөгөөд энэхүү ажлын амин сүнс юм.”

**Католик сүмийн эцэг, Юкаристийн нийгэмлэг,
үндэслэгч Николас Бутет
Сант Морис, Швейцар**

“Энэ бол Христийн бие хамтдаа нэгдэж, бидний Аврагч амилсан, Тэр одоо ч амьд, дахин ирэх болно гэдгийг бүх дэлхийд гэрчлэх агуу боломж гэж бодож байна. Би таныг залбирч, энэ гайхалтай хөдөлгөөний нэг хэсэг болохыг уриалж байна. Мөнхийн улсад та үүнд нэгдсэндээ баяртай байх болно.”

**Empart, үндэслэгч ба ерөнхийлөгч
Жоси Шако
Австрали**

“JC2033 хөдөлгөөний тухайд би маш их сэтгэл хөдөлж байна. Энэ бол Христийн Амиллын талаар хүчирхэг мэдээг хүргэх боломж. Ойрхи Дорнодын Христитгэгчдийн нөхцөл байдал маш хүнд байгаа. JC2033 тэдэнд агуу урам зориг, найдварыг өгөх болно. Тэр дундаа бүх юмаа алдчихаад байгаа хүмүүст.”

**Дэлхийн чуулгануудын зөвлөлийн Ойрхи Дорнодын
чуулгануудтай харилцах харилцаа Карла Кижоян
Швейцар**

“Бүх үндэстэн, хэлтэн, янз бүрийн угсаа гарал, итгэл үнэмшлийн ялгаатай хүмүүстэй Есүсийн амиллыг тэмдэглэнэ гэдэг үнэхээр л мөнхийн улсын нэгээхэн дүр зураг мөн.”

**Европын судалгааны Шуман төв,
хамтран удирдагч Ромке Фаунтен
Нидерланд**

“Эв нэгдэл дотор бид Христийг Эзэн ба Аврагч гэж тунхаглах эрх мэдэл, хүчийг олдог. Түүний амиллыг бид хамтдаа тэмдэглэж чадвал энэ нь бүх дэлхийд нөлөөлөх болно.”

Kasr El Dodara чуулганы пастор Др.Саме Морис

Кайро, Египет

“2033 онд Бидний Эзэн Есүс Христийн Амиллын 2000 жилийн ойг тэмдэглэхээр чуулганууд нэгдэх санааг би хүлээн авч, Бүхнийг чадагч түүнээс энэ харааг санаачлан эхлүүлж, энэхүү ялгуусан өдрийн төлөө шаргуу бэлтгэж байгаа бүхнийг ерөөхийг гуйж байна.

“Tavus Армений Апостол чуулганы хамба лам Баграт

Эчмиадзин, Армен

“Энэ санаачилга Бурханаас эхлэлтэй гэдэгт би бүрэн итгэлтэй байна. Энэхүү харааг би 100 хувь дэмжиж, бүх үндэстнээс Христийн бие хамтдаа нэгдэж, түүхэн дэх хамгийн агуу үйлс болох бидний Эзэн Есүс Христийн амиллыг тэмдэглээсэй гэж хүсэж байна.”

**Христийн сайнмэдээг бүх 245 оронд тунхагласан
анхны хөгжимчин гэсэн дэлхийн рекордыг эзэмшигч**

Бенни Прасад

Энэтхэг

“Есүс дагалдагч нараа залбирахдаа “Бидний Эцэг минь!” гэж залбирахыг заасан. Гэр бүлээрээ цуглахад дургүй байх ямар эцэг хүн байх билээ? JC2033 бол дэлхий харж байгаагүй хамгийн том “гэр бүлийн цугларалт” юм. Есүсийг баярлан тэмдэглэнэ гэдэг нэр нь бүх нэрнээс агуу Нэгэний агуу ялалт! Wow, үнэхээр агуу том зүйл болох нь ээ!”

Gateways Beyond, захирал Бедрос Нассаниан

Женев, Швейцар

“Ази хүний хувьд Бурхан Оливерийн зүрхэнд өгсөн зүйлийн төлөө маш их баяртай байна. Есүсийн Амиллын 2000 жилийн ойг тэмдэглэнэ гэдэг бол Бурханы хайрыг

болон амиллаас ирдэг агуу хүчит эрх чөлөөг харуулах татгалзахын аргагүй боломж билээ.”

**Филиппины илгээлтийн АНУ дахь зохицуулагч
Аурелио Лосео
Хавай, АНУ**

“Энэ ажил хэрэг миний сэтгэлд тун таатай санагдаж байна. Маш их боломж энд байна. Зөвхөн Христийг төв болгож гэмээнэ эв нэгдэл бий болно. Ирээдүй бол сүнслэг эв нэгдлийг хангагч ийм үйл хэргүүдэд зориулагдсан билээ.”

**Дэлхийн чуулгануудын зөвлөлийн Пентекостуудтай
харилцах харилцаа, тэргүүлэгч асан. Дуглас Чайал
АНУ**

“Энэхүү том харааг Бурхан үргэлжлүүлэн батжуулж, Христийн биед үүнийг түгээн тараахад тань мэргэн ухаан хайрлах болтугай!”

**ELIM чуулганы тэргүүн Жон Гласс
Англи**

“Энэ бол гайхамшиг үйлдэгдэж байна гэхээс өөр аргагүй Бурханы санаа. Оливер энэ харааг чин хүсэл эрмэлзэлтэйгээр тээж яваа нь бүгдэд түгээгдсээр байна. Есүсийг өргөмжлүүлэх түүний хүсэл ба зориулалтанд бид туйлаас дуртай. Хамгийн чухал Нэгэн болох Есүс өөд хүрэх зам руу үргэлж чиглүүлж байдагт нь Оливерт баярлалаа!”

**Beacon Hill, ахлах пасторууд Майкл & Шерил Суа
Шинэ Зеланд**

“Бидний итгэлийн гол цөм бол Христийн амиллын үйл явдлуудаар дүүрэн (1 Кор 5:14) бөгөөд JC2033 хөдөлгөөнөөр дамжуулан бүх үндэстний дагалдагч нарын дунд улам ч дүүрэх болно. Энэхүү түүхэн үйл явдал ерөөл дүүрэн байхыг хүсье!”

**Дэлхийн чуулгануудын зөвлөлийн Сайнмэдээ,
гүйцэтгэх захирал асан Карлос Е. Хам
Куб**

“Энэхүү түүхэн үйл явдлыг тэмдэглэхэд тань үүд хаалга бүр нээгдэх болтугай. Бүх дэлхийгээс магтаал, хүндэтгэл өргөгдөг!”

Emeritus, ерөнхийлөгч, Үүрэгтэй залуус, Олон улсын зохицуулагч Жон Даусон АНУ

“Бидний Эзэн Есүс Христийн амиллыг тэмдэглэхээр дэлхийн бүх Христитгэгчид эвлэлдэн нэгдэхээр дуудагдаж байна. Эх оронд нь нар мандахтай зэрэгцэн нэгэн дуугаар Хүүг магтан дуулахаар Христэд итгэгчид нэгдэхийг харж, сонсоно гэдэг юутай ялгуусан зөн хараа вэ? Энэ санаачлагад нэгдэхийг би танд уриалж, ирэх жилүүдэд үүнийг бодит болгохын тулд хамтран ажиллахдаа бид эвдэрч, хуваагдсан дэлхий дээр буух Бурханы ерөөлийг харна гэж залбирч байна.”

Дэлхийн зөвлөлийн удирдагч, Лузанн хөдөлгөөн. Гүйцэтгэх захирал, Leading Global Impact Даниел Виллис Австрали

“Оливер бол Швейцарын YWAM-ын захирал байсан хүн. Тэрээр 250 стафф, жил бүр 300 оюутан ирдэг зургаан сургалтын төв болон үйл ажиллагааны зургаан байршлыг хариуцаж байсан. Тэр бол үнэнч шударга, удирдаж байсан хүмүүстээ өндрөөр үнэлэгдсэн хүн. Орон нутгийн чуулгануудтай хамтарч, амжилттай яваа Альфа курсыг явуулдгаараа бүс нутагтаа сайн танигдсан. Тэр бол шинээр үйлчлэлүүд эхэлж, Бурханы хаанчлалын төлөө итгэлээ сориход нь болон стратеги боловсруулахад нь бусдад тусалж чаддаг алсын хараатай хүн. Түүгээр ч зогсохгүй зорьсондоо итгэмжтэй хүрдэг, шалгарсан зан чанартай залуу. Би түүнийг эртнээс мэдэх бөгөөд Бурханы хүн, YWAM-ын тослогдсон удирдагч, Христийн бие доторх эрхэм чухал хүн хэмээн үнэлдэг.”

YWAM Европ, удирдагч Стефен Мэйэрс Испани



ОНЦГОЙ ТАЛАРХАЛ

Энэхүү номыг бодит ажил хэрэг болоход тусалсан бүх хүнд онцгой талархал илэрхийлье.

Юун түрүүнд эхнэр Силвиандаа талархъя. Улирах он жилүүдийн турш чи минь миний итгэмжит хамтрагч байсан. Эхнээсээ л надад итгэж байсанд чинь баярлалаа. Чи намайг энэ ажил хэргийг гүйцэлдүүлэхэд урамшуулан дэмжсэн. Хамтдаа бид тодорхойгүй байдлын манан дундуур гарч, гайхалтай, заримдаа галзуу гэмээр заримдаа сэтгэл хөдөлгөсөн аялалыг туулсан. Амар тайван, тэвчээртэй зан чинь манай гэр бүлийн тогтвортой байдлын эх үндэс болж байдаг шүү.

Мэргэн ухаантай, ачлалтай эмэгтэй чамдаа баярлалаа. Бидний баяр баясгалан болсон хоёр хүү Натаан, Рейми хоёртоо амьдралын гайхамшигтай хором мөчүүдийг хуваалцдагтаа баярлаж талархдаг шүү.

Энэ даруухан номны бэлтгэл ажилд оролцсон бүх хүмүүстээ томоос том талархлыг өргөө. Талбар бүрийн авъяаслаг хүмүүсийн хамтын хичээл зүтгэл, олон зуун цагийн зориулалт нь багийн ажиллагааны шагнал байлаа. Энэ ажлыг зүлгэж, өнгө оруулсан та нартаа баярлалаа. Миний хичээнгүй бичээч Иоел Реймондын нөхөрлөл, тустай зөвлөгөө, үр дүнтэй ажилд талархал илэрхийлье.

Миний дуртай теологич, түүхч, анд найз Паул Хеместээ, амиллын он цагийн тухай ээдрээтэй сэдвээр надад өгсөн зөвлөгөө, мэргэн ухаанд чинь баярлалаа.

Энэ сэдвээр хийсэн чиний гүнзгий судалгаа, олон талын дүн шинжилгээ энэ номын сүүлчийн хоёр бүлгийг илүү тодорхой болгож өгсөн билээ.

Олон цаг сууж, номд өгүүлэгдсэн гайхалтай түүхүүдийг нэгтгэн оруулсан Корин Лиехти, Анн Роберт хоёртоо яаж талархснаа илэрхийлэх билээ? Та хоёртоо маш их баярлалаа.

Янз бүрийн бичвэрүүдийг маань хянан уншиж, теологийн халуун сэдвүүдийг цэгцэлж өгсөн бүх хүнд баярлалаа. Мэдээж зарим нь одоо ч ... хэвээр, бидний ариусгал үргэлжилсээр байгаа! Урсгал чиглэл, ахуй соёлын мэдрэмжгүй байдалд минь тусалсан та бүхэнд баярлалаа.

Хамтран зүтгэгч, анд найз, миний англи хэлний хоёр дахь тархи болсон Жэйсон Холлинжер. Хүн уншчихаар түүх болгох гэж анхны бичвэртэй минь олон цаг ноцолдсонд чинь баярлалаа. Миний бичвэрийн хэв маягийг илэрхийлж чадахуйц англи хувилбарыг бий болгоход зориулсан олон цагийн ажилд талархаж. Даруу байдал, үнэнч сэтгэл, өөрийгөө гаргуунд хаяад зориулдаг гайхалтай чанар, хатуу чанд сахилга бат бол чиний зан чанарын зөвхөн нэг хэсэг нь. Бүтээлч байдал чинь намайг байнга алмайруулдаг. Чиний төлөө, шаргуу хөдөлмөрийн чинь төлөө би талархаж байна. Чамгүйгээр энэ ном бичигдэхгүй байх байсан.

Миний хэл зүйн дүрмийн алдааг засахаар цөхрөлтгүй ажилласан хүмүүстээ баярлалаа. Та нарын суут ухааны ачаар хэл зүйн дүрэмдээ би ямар муу болохыг дэлхий мэдэхгүй өнгөрөх нь.

Скот МакКлейрын хянан тохиолдуулах гаргууд чадварт, Грегорий Тарфдаа орчуулгын ажил урагшлахад туслалцаа үзүүлсэнд, Жорж ба Жиано Хауке нартаа хяналтын уншлага хийсэнд баярлалаа.

Бидний төлөө залбирч, санхүүгээр дэмжсэн хүмүүсээ онцгойлон цохон тэмдэглэмээр байна. Тэдний зарим нь, эхнэр бид хоёр хорин жилийн өмнө

анх хүмүүсийн санхүүгийн дэмжлэгээр амьдарч үйлчлэх шийдвэр гаргасан үеэс дэмжиж ирсэн хүмүүс. Та бүхний өгөөмөр сэтгэлийн үрээр бид Бурханаас өгсөн дуудлагаа үргэлжлүүлж яваа билээ.

Энэ бүгдийн дээр эцсээ хүртэл итгэмжтэй байсан, миний төлөө загалмайд хүртэл цовдлогдсон Нэгэнд талархал өргөө. Хүртэх зохисгүй надад нигүүлслээ хайрласан Түүнд, зүрх сэтгэлээс минь баяр хөөртэйгээр гарч бусад руу урсаж байдаг амиллын хүчийг нь өдөр бүр амсаж амьдрах тавиланг хайрласан Түүнд. Өөрийг минь ялгадсан овооноос өргөж гаргасан Есүс танд баярлалаа. Та намайг цэвэрлэн угааж, хоёр дахь боломжийг олгон, шинэ амьдрал бэлэглэсэн билээ.

Зөвхөн Бурханд алдар нь байг.

ӨМНӨХ ҮГ

Оливер Флюри

Та 2033 оны 4 сарын 17-ны өглөө юу хийж байхаа мэдэх үү?

Би бол юу хийж байхаа мэднэ. Алс холын ирээдүйд өөрийгөө аваачаад төсөөл дөө гээд хүмүүсээс асуухаар огт төсөөлөгдөхгүй байхаас аргагүй. Ихэнх хүмүүс долоо хоногийн дараа гэхэд хаана байхаа, маргааш юу идэхээ, сарын дараа ямар ажил хийж байхаа хэлж мэддэггүй шүү дээ.

“Та 2033 оны 4 сарын 17-нд юу хийх вэ?” Дэлхийн эргэн тойронд байгаа хүмүүсээс би энэ асуултыг асуусан. Зарим хүмүүс нүүрэндээ инээмсэглэл тодруулна, зарим нь эргэлзсэн байдалтай хөмсгөө буулган над руу харна. Ихэнх хүмүүс гайхаж, зарим нь толгой дотроо хэдтэй байх билээ, тэтгэвэрт гарсан байх билүү, хүүхдүүд нь хэд хүрсэн байх билээ, амьд байх болов уу гэхчлэн янз бүрийн юм тооцоолж байгаа харагддаг. Ерөнхийдөө хүмүүс намайг ямар ч ач холбогдолгүй асуулт асуугаагүй, чухал утга учиртай асуулт асуусан гэж таамагладаг байх. Энэхүү холыг харсан ажил хэрэг бол энэ номын гол сэдэв.

Одооноос хорин жилийн дараа тогтоогдсон тэр өдөр юу болохыг мэдэх... энэ ятгалга бол миний өөрийнх биш, харин миний Бурханых, Есүс Христээр дамжуулан Өөрийгөө илчилсэн Нэгэнийх билээ.

Би бусадтай л адил энгийн, жирийн хүн гэж өөрийгөө хардаг. Харин энэ нүдээрээ би Библид гардаг шиг, ер бусын байдлаар илчлэгддэг үзэгдлийг, өөрөөсөө гадна орших нэгэн үзэгдлийг харсан юм. Элч Паул амилсан Христийг үзэгдлээр харсныхаа дараа Христитгэгч

болсон. Христийн амиллаас хойш 40 хоногийн турш олон зуун хүн яг үүнтэй адил зүйл үзэж амссан. Өнгөрсөн 2000 жилийн турш сая сая эрчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүд хувьдаа илчлэл авсан байгаа. Надад юу тохиолдсныг, түүнээс хойш юуг чин хүсэл эрмэлзэлтэйгээр мөшгөсөөр байгаагаа би танд хүүрнэн өгүүлье.

Та төсөөл дөө...

Та төсөөл дөө! 2033 оны Ням гарагийн Амилсан баяраар үүр цайж, шинэ өдөр эхэлж байгааг.

Та төсөөл дөө! Түүхэн дэх хамгийн агуу тэмдэглэлт баяр, Есүс Христийн амиллын 2000 жилийн ойг.

Та төсөөл дөө! Дэлхийн бүх бүс нутагт байгаа итгэгчид дэлхий даяар хамт цуглана гээд.

Та төсөөл дөө! Бодит хайр, жинхэнэ эв нэгдлийг чуулган энэ дэлхийд харуулна гээд.

Та төсөөл дөө! JC2033-ыг.

ҮЗЭГДЭЛ

Киноноос ч илүү бодит, тод зураглал нүдэнд минь харагдав. Газрын татах хүч надаас зугтана. Нүдний минь өмнө манай цэнхэр гараг дээр нар мандаж байна. Сэрж буй дэлхий дээр нарны эхний цацраг цагийн бүсний дарааллаар тусмагц дэлхийгээс гэрлийн цацраг гарч огторгуйд тусаж байгааг би харлаа. Мянга мянган ийм гэрлэн багана дэлхий даяар тархан тусаж, хоосон огторгуйн харанхуйг гэрлээр дүүргэж байлаа.

Манайх 2007 онд Швейцараас нэг жилийн хугацаагаар Австрали руу явсан юм. Гол зорилго нь Сиднейн захад орших Оксфорд Фолсд байдаг, Christian City Church (C3) чуулганы харъяа олон улсын сургуульд сурч Библийн мэдлэгээ дээшлүүлэх гэсэн хэрэг.

2007 оны зуны сарууд дуусах дөхөж байв. 3 сарын 7-ны өглөө би шууд хичээлдээ явах ёстой байв. Өчигдөр өглөө нь хөвгүүдээ хүргэх ээлжээ гүйцээчихсэн болохоор тэр л дээ. Өнөөдөр харин эхнэрийн ээлж учраас эхнэр маань хүүхдүүдээ зохицуулах зуур би нэг гартаа цүнхээ, нөгөө гартаа Библиэ барин, шарсан талхан дээр түрхсэн зөгийн балыг доош дусаачихгүйг хичээн амандаа зуусан хэвээр гэрээсээ гарлаа.

“Өдрийг сайхан өнгөрүүлээрэй Натаан, Реми”, “Удахгүй уулзая Силвэйн!”

Хөрш Сарагаа удаан хүлээлгэхийг хүссэнгүй. Нэг хичээлд сууж байгаа болохоор сайхан сэтгэл гарган хүргэж өгөхөөр болсон юм. Агаар цэнгэг сайхан байлаа. Өглөөний 7 цаг болж байгаа ч нарны элч аль хэдийн

мэдрэгдэж, шувууд хөгжөөнтэй жиргэх сонсогдоно.

Гайхалтай баяр хөөр төрж байсан тул би Бүтээгчээ магтаж, хичээлийн шинэ жилийн төлөө талархаж эхэллээ. Бурханы оршихуй миний хажууд, эргэн тойронд мэдрэгдэн сэтгэл догдлуулж байлаа. Цэнхэр гарагийн агаар мандлаас дээш, тэнгэрийн улсын нууцлаг оршихуйд харцаа шилжүүлэн тэнгэр өөд харав. Өнөөдөр нэг л онцгой өдөр болох нь. Дотор минь байгаа бүхэн ямар нэгэн сайхан зүйлийг хүсэн хүлээж байгаа санагдлаа.

Тэр өглөө СЗ чуулганы хөдөлгөөн болон Оксфорд Фолс Библийн Сургуулийг үндэслэгч Фил Фрингл их танхимд үг хуваалцах байв. Сар бүр 450 оюутан, сургуулийн ажилчид хамт цуглаж, магтаал хүндэтгэл өргөн, дараа нь сургуулийг үндэслэгч үг хуваалцдаг юм.

Намайг ирэхэд магтаалын баг бэлтгэлээ хийгээд завгүй байв. Би урд хавиар очоод тухтай суудал олж, гурав дахь эгнээнд суув. Бурханы оршихуй эргэн тойронд мэдрэгдэж, их танхимын хананууд Бурханы зүрхний цохилтоор цуурайтах мэт санагдана. Магтаалын баг хөгжмөөр хоршин нэгэн хөг, хэмнэлээр тоглоно. Бөмбөр жигд хэмнэлээр цохиж, даралтат хөгжим танхим дүүргэн уянгалан, гитар цахилгаан долгион дамжуулна. Бид байгаа бүхнээрээ Бурханыг хүндэтгэн талархал, магтаал өргөв.

Би Бурханыг магтах туйлаас дуртай. Бусад итгэгч нарын хамт Бурханыг магтах тэр л мөчүүдэд Бурхан миний зүрх сэтгэлийн гүний гүнд хүрч, сэтгэл хөдлөл, хүсэл хэрэгцээ бүхэн минь Түүний өмнө ил болдог билээ. Энэ өглөө харин жирийн бус зүйл тохиолдов. Хэдийгээр бие минь бодит ертөнцөд оршин байвч нүдээрээ сүнслэг ертөнцийг харж эхлэв. Давхцан орших хоёр ертөнц тусгаарлагдаад ирэх шиг болж, нэг нь бодитоор оршсон хэвээр, харин нөгөө нь миний сүнслэг нүдний өмнө кино зураг мэт өрнөж эхэллээ. Ариун Сүнс намайг дүүргэж, Түүний оршихуй надад үзэгдэл үзүүлэв. Би үүнийг харж, мэдэрч, оюун ухаанаараа ойлгож чадаж байлаа.

Хоромхон зуур би эргэж буй дэлхийн бөмбөрцгийг

гадаад сансраас харж байв. Дэлхий сэрж буй бололтой. Харанхуй арилж, үүрийн гэгээ тусаж буй заагийг би харлаа. Цагийн бүсийн дагуу гэрэл улам ихээр гийгүүлж, гэрэл туссан зурвасыг даган гэрлийн цацрагууд тэнгэр өөд тусан гэрэлтэв. Тэрхүү гэрлийн тусгал аюултай, хортой биш харин ч эсрэгээр илч дулаан, баяр хөөр, хайрыг түгээж байлаа. Аяа! Юутай зүйрлэшгүй гоо үзэсгэлэн, хүч чадал нүдний минь өмнө дүрслэгдэх нь энэ вэ?

Тэгтэл гэнэт үй олон хүн дээр хараа минь тусав. Арьс өнгө, гадаад төрхөөрөө ялгаатай мянга мянган хүн цугларан Бурханыг магтаж байв. Цэнгэлдэх хүрээлэн, цэцэрлэгт хүрээлэн, хотын төв, хөдөө тосгон, өргөн тал хөндийд хаана л хүмүүс байна тэнд магтаал оршиж байв. Дэлхийгээс цацарч байсан гэрэл нь энэ ажээ. Цаашилбал, дэлхийг хучсан тэрхүү гэрэлт өглөө нь Амилсны Ням гараг байв. Зүүнээс баруун тийш, цагийн бүсийн дагуу мянга мянган хотод сая сая хүмүүс Бурханы үнэнийг гэрчилж, Түүний амиллыг тэмдэглэж байлаа.

Хэсэг азнаад би доош суун, харсан зүйлээ бичиж авах хэрэгтэй санагдав. Сая харагдсан зүйлсийн гол чухлыг алдчих вий хэмээн бодогдож, харсан үзэгдлээ зургаар дүрслээд тайлбартай хамт цаасан дээр буулгах санаа төрөв. Гэвч Бурханы надад харуулах зүйл ингээд дуусчихаагүй бололтой. Магтаалын баг магтаалаа үргэлжлүүлж, би Бурханыг чин сэтгэл зүрхээр магтахаар дахин бослоо.

Гэтэл бодлууд дахин сүнсийг минь дүүргэж, бага багаар бүх юм эвлэн, би доош сууж юм бичиж тэмдэглээд дахин босож үргэлжлүүлэн магтаж, тэгээд дахин сууж Бурханы илчлэлтээр хуудас цааснуудыг дүүртэл бичиж авлаа.

Бурханыг сонссон нь дээр

Зүрх минь сэргэлт мэдрэн цохилж байв. Анхны чуулганы үед Бурхан хүмүүсийн зүрхийг хэрхэн хөдөлгөж байсан талаар элч нарын Үйлс номд бичигдсэн байдаг. Бурхан одоо бидний зүрхийг хөдөлгөж байна уу? Бурханы оршихуйд орох гэж үүнийг хэлдэг юм уу?

Бурханы хайрын дүүргэлтийг би анх удаа мэдэрч байгаа нь энэ биш юм. 10 жилийн өмнө 1997 онд Техас мужийн Даллас хотод “Христийг үндэстнүүдэд институт” (Christ for the Nations Institute) хэмээх Библийн Сургуульд сурч байх үед Ариун Сүнс бидний дунд маш хүчтэй ажиллаж, хоёр долоо хоногоор хичээл завсарлаж байсан билээ. Оюутнууд унталгүй шөнөжин залбирч, Бурханы хувьчилсан хүрэлтийг амсаж байв. Бид гэмшиж, Түүнийг магтан хүндэтгэж, Есүстэй харилцаагаа гүнзгийрүүлж, хөлс, нулимс урсгасан цагууд байсансан.

Магтаалын цаг дуусах дөхөж, Фил тайзан дээр удахгүй гарах байв. Би түргэхэн Фил дээр очоод Сүнсэнд мэдрэмжтэй байж, тайзан дээр гарахаа азнахгүй юу гэж хэлмээр бодол төрөв. Бурхантай ярилцаж байсан цагаа үргэлжлүүлэх нь надад Филийн хуваалцах үгэнд анхаарлаа хандуулснаас хавьгүй илүү баялаг санагдаж байлаа. Юу хийх гэж байгаагаа дахиад нэг бодоод үзвэл арай ч хийчихмээргүй санагдав. Фил Фрингл бол дэлхий даяар 300 гаруй чуулганыг хариуцаж яваа нэр хүндтэй хүн, мэдээж Бурханы хүн, чухал үг дамжуулж таараа. Халаг гэж, нэгэнт оройтсон гэж харагдсан тул би дотроо тэмцэлдэхээ зогсоолоо. Хэзээний тамирчин мэт хөнгөн шингэн алхаагаар Фил тайзан дээр гараад ирлээ. Харин миний хувьд “тэнгэрлэг файлуудыг татаж авах” үйл явц үргэлжилж, Бурханаас үүнийг зогсоохгүй байхыг гуйлаа. Фил бидэнд хандан:

“Анд нөхөд өө, та бүхэн энэ өглөө надтай адилхан зүйл мэдэрч байгаа гэж би итгэж байна. Бурхан бидний зүрх сэтгэлд гайхалтайгаар ажилласаар байна. Би үг хуваалцалгүй, Есүстэй нөхөрлөх эрх чөлөөг та нарт олгохоор шийдлээ. Та бүхэн түүний бэлтгэсэн бялхам дүүрнээс нээлттэйгээр хүлээн аваарай” гэлээ. Бурханыг магтая!

Дараагийн хагас цагийн турш танхимд хүмүүсийн хувьчилсан залбирал, хувийн мөргөл өрнөв. Уур амьсгал хүмүүсийн хувийн зориулалт, Бурханы төлөө гэсэн гал

дөлөөр бадарч байв. Болж байгаа зүйлд мэдрэмжтэй хандсан Филийн уриалгын ачаар би Бурханаас хүлээн авч байсан үзэгдэл рүүгээ чавх мэт буцан харвалаа.

Энэ удаад би тодорхой үгсийг сонсов.

Бүх дэлхий Христийн амиллын 2000 дахь жилийг тэмдэглэхэд оролцох болно. Ямар ч үндэстэн, овог үлдэж хоцрохгүй, мартагдахгүй. Амилсан баярын тэр өглөөний гэрч болохоор цугласан олны дээр баяр хөөр, догдлол дүүрэн бялхах болно. Энэ бол баяр хөөртэй цаг үеийн дээд оргил байх болно. Гэхдээ энэ тэмдэглэлт баярыг Христийн дахин ирэлттэй ямар ч тохиолдолд холбож болохгүй гэдгийг санаарай. Христ хэзээ дахин ирэх нь чиний санаа зовох зүйл биш. Тэр өмнө нь ч, тэр үеэр ч, үүний дараа ч ирж болно. Тэнгэр дэх Эцэгийн шийдсэн үед Христ дахин ирэх бөгөөд үүнийг мэдэх нь хүний хэрэг биш.

Тэгээд Фил микрофоныг гартаа авав. Тэрээр Бурханд талархаад, Ариун Сүнсэнд чих тавьсан хэвээр байхыг бидэнд уриалав. Харин би энэ тэнгэрлэг уур амьсгалаас холдохыг хүсэхгүй байлаа. Ингээд дуусчихгүй гэсэн мэдрэмж надад төрөөд байв. Бусад жирийн өглөөтэй л адил хийдэг зүйлсээ хийж би төвдсөнгүй. Сонсох ёстой, өөртөө шингээж, бичиж авах ёстой маш их зүйл байгаа. Би маш их ядарч, бараг л толгой эргэж байгаа юм шиг санагдаж байсан хэрнээ эрч хүчтэй, сэргэг байлаа. Хүмүүс танхимаас гарч эхлэх үед би хичээл эхлэхээс өмнөх давчуу цагтаа амжуулан сүүлд төрсөн хэдэн бодлуудыг буулгаж авлаа.

Ой ухаанд үзэгдээд өнгөрсөн зураглалууд дунд би маш том зарлалын самбар дээрх зарлалуудыг олж харав. Дэлхийн хэвлэл мэдээлэл энэ үйл явдалд анхаарлаа хандуулжээ. Зарим нь тохуурхаж, Христигтэлтнүүд өөрсдөдөө анхаарал татахыг оролдож байна хэмээн буруутгаж байв. Ямар ч зорилготой бай, бүх хүн Есүсийн

талаар ярилцаж, Түүний дахин төрөлт гэж хэлж болох Амиллын 2000 жилийн ойн тухай сонсоогүй нэг ч хүн дэлхий дээр байсангүй.¹ Христитгэгчид итгэлээ зоригтойгоор тунхаглаж байв. Дэлхийн эргэн тойронд маш олон цугларалт болж бүр тоогоо алдсан байв.

Израилын тухай үзэгдэл

Толгойндоо цагтай гэмээр над шиг Швейцар хүний хувьд хичээлээс хоцорно гэдэг ихэд даруусгасан хэрэг билээ. Хоцроод зогсохгүй хамгийн сүүлд ирэв. Профессор Бретт Барклейн хичээлээ эхэлчихсэн оюутнууд тэмдэглэл хөтлөхөд бэлэн болсон байлаа. Бретт багш бол Бурханд хайртай гэдэг нь Ариун Сүнсний онгодоор ярихад нь илхэн харагддаг, аливааг гүнзгий тунгаадаг, оюутнуудад хуваалцах арвин баялаг мэдлэгтэй хүн. Түүнийг ярьж эхэлмэгц би нөгөө сүнслэг ертөнц рүү яваад орчихов.

Энэ удаад харин кино зохиол мэт, гол сэдэв нь Есүсийн амилсан ариун хот Иерусалим дээр төвлөрч байв.

Олон хүн амилсан баярыг Иерусалимд тэмдэглэхийг хүсэх болно. Бид Израилын засгийн газарт маш олон мөргөлчид дэлхийн эргэн тойрноос Иерусалим хот руу ирэх болно гэдгийг мэдэгдэв. Аюулгүй байдлын үүднээс ямар нэг юм зохион байгуулахыг тэд хориглож, хотод хамгаалалт гаргав. Тэд биднийг тал газар дээр цуглар хэмээн хойд зүг рүү явуулахад би тэнд нэгэн нисэх онгоцны буудал харав. Иргэний агаарын тээврийн онгоцнууд дэлхийн өнцөг булан бүрээс ирж, онгоцны зам дээр буун, автобуснууд зорчигчдоор дүүрсэн байв. Энэ тал газар маш өргөн уудам бөгөөд цугласан хүмүүсийн тоо хэдэн зуун мянга байх гэсэн таамаг төдий.

Толгойд минь орж ирсэн бүхнийг буулгах гэж гар минь чилж байв. Цагаа нэг харснаа ангид юу болж байгаа талаар ямар ч ойлголт байхгүй байгаагаа би гэнэт ухаарав.

Дөчин минутын турш өөр зүйлд анхаарсан байлаа. Тэгтэл Бретт:

“Оливер, чи энэ талаар юу гэж бодож байна?” гэх сонсогдов.

“Өө, намайг үнэхээр уучлаарай. Би таны асуултыг сонссонгүй” гэж хэлээд

“Яг үнэндээ бол би таны хэлсэн нэг ч үгийг сонссонгүй. Би яг одоо өмнө нь хэзээ ч тохиолдож байгаагүй зүйлтэй тулгараад байна л даа. Би хичээлээ нөхөөд авчихнаа, тэгээд дараа нь танд үүнийг дуртайяа тайлбарлая. Гэхдээ яг одоо бол би өнөөдрийн сэдвээс огт хөндийрчихсэн байдалтай байна” гэж тайлбарлалаа.

“Болж байна. Чи хүсэж байгаа бол дараа энэ талаар ярилцая.”

Тэрээр намайг нэг шинжин харснаа, үргэлжлүүлэн ярьж эхлэв. Ингээд би нөгөө бодлууд руугаа эргэн шилжив. Жижиг боодолтой илгээмж мэт, хэсэг хэсэг мэдээллүүд ар араасаа цувран ирж, гулгуур дээр хүүхдүүд гулгах ээлжээ хүлээж байгаа юм шиг овоорсоор байсан тул агуулга санааг нь цааш дэлгэрүүлэх цаг надад байсангүй.

Тэгтэл арван таван минутын завсарлагааны хонх дуугарч, ном хаах, сандал дуугарах, сурагчид хоорондоо ярилцах зэргээр эргэн тойрон хөдөлгөөнд оров. Аль нь ч намайг сатааруулсангүй. Эргэн тойронд өрнөж байсан ямар ч ярианаас миний дотор өрнөж байгаа яриа илүү тод байлаа.

Нөлөө бүхий олон хүмүүстэй уулзах хорин жилийн хугацаа байна. Энэ үзэгдэл, хараа илүү өсч томрохын тулд би бусадтай хуваалцах ёстой болно. Эрх мэдэлтэй, өндөр үүрэг хариуцлага үүрдэг хүмүүс үүнийг сонсох ёстой. Би ганцаараа байхгүй. Өөр хүмүүс байгаа. Бурхан тэр хүмүүстэй ярилцаж байгаа. Би тэр хүмүүсийг олох хэрэгтэй, Бурхан минь, Та тэдэн рүү намайг хөтлөн дагуулаарай.

Хонх дахин дуугарч анги хичээлээ үргэлжлүүлэхээр бэлтгэж байв. Би юмаа аваад багшдаа эелдэгээр дохио

өгөөд хаалгаар гарч, анги руугаа ирж байсан оюутнуудтай зөрөөд өнгөрлөө.

Хичээл орж байх хооронд би сургуулийн мөргөлийн танхимд орж “хоргодов.” Тухтай буйдан, хивс бүхий энэ дугариг өрөө Бурханы оршихуйд байхад төгс тохирох газар байсан учир сонсохоор бэлтгэн юмнуудаа зэхэх зуур “татаж авах үйл явц” үргэлжиллээ.

Энэ удаад Библийн эшлэлүүд урган гарч ирэв. Ар араасаа өөр өөр эшлэлүүд толгойд бууж, өмнө нь хэзээ ч харж байгаагүй өнцгөөс олж харлаа. Яг л Хуучин Гэрээ судлалаар түргэвчилсэн давтлага Есүсээс авч байгаа мэт. Египетээс гарч, цөлөөр хэрэн явж, амлагдсан газар очихоо хүлээн байгаа еврейчүүд дээр миний анхаарал төвлөрч байлаа. Тэд бол бүх үндэстнүүдэд ерөөл болохоор сонгогдон, амлалтыг хүлээн авсан Абрахамын залгамж халаа.² Мосегийн үеийн израилчууд гайхамшгуудыг харсан шиг зарим чуулганууд гайхамшгуудыг харсан байдаг. Гэсэн хэдий ч, тэд ч мөн адил нэг л тойрогтоо эргэлдсээр, чуулганы хананы цаадхаас илүү ханан дотроо болж байгаатай зууралдсаар байдаг. Есүс чуулганд даалгасны дагуу бид явж, бүх үндэстнийг дагалдуулах үедээ³ тэдэнд ерөөл болох болно.

Хэсэг хугацааны дараа, би арай өөр түвшин рүү шилжиж байгаа гэж мэдрэгдэж, компьютерийн хэллэгээр бол “байршуулах” (upload) гэдэг үгтэй яг тохирох үе дээр ирэв. Бурханаас хүлээж авах нь зогсож, одоо харин буцааж өгөх, гэхдээ илүү чухал нь энэ харааны төлөө залбирах, үүнийг тээж, усалж тордох, чуулганууд үүнийг хүлээж авахын төлөө залбирах ёстой боллоо. Энэ хараа яг л дөнгөж төрсөн нярай шиг нялх, шинэхэн, эмзэг байв. Би Бурханаас хүч тэнхээ хайрлаж, намайг орхихгүй байхыг, эд эс дотор минь нэвчин орж чадсан энэ л гайхалтай харааг хадгалж хамгаалахыг гуйлаа.

Бурхантай хоёулхнаа байсан сүүлийн энэ үйл явдал гэхэд л үлдсэн бүх эрч хүчийг минь шавхаж, пицца хийхээр элдсэн гурил шиг намайг сунгалаа. Шалан дээр сунан хэвтсэн бие минь цэвэршүүлэх зорилготой зууханд

шатаагдаж, сүнс минь Түүн рүү нулимстайгаар хашхирч, толгойг минь даган хөлс урсаж байсан. Би Бурханыг дуудан хашхирсан, ялалтыг тунхагласан, Бурханы өмнө байж болох бүх л ил цагаан байдлаараа ичгүүргүйгээр ирсэн. Бурханы оршихуйг би амьдралдаа ийм бодитоор хэзээ ч амсаж мэдэрч байсангүй. Хэдийгээр энэ бүхнийг би нүдээрээ бодитоор хараагүй ч, бусад бүх л мэдрэхүйгээрээ энэ бол Бурхан байсныг мэдэж байлаа. Би Түүнд дуулал, магтуу дуу дуулж, хэн болохыг нь хүндэтгэн алдаршуулав. Түүний оршихуй хүчирхэг атлаа зөөлөн, эрслэн гүегнүүдээ амандаа зуухтай адилтгам байв. Энэ эсрэг тэсрэг байдал юутай сэтгэл хөдөлгөм. Хэсэг хугацааны дараа бүх юм намжиж, Бурханы нигүүлсэл намайг гайхаж алмайрсан мэдрэмжээр дүүргэж, сэтгэл санаа минь хүчирхэгжсэн ч бие ямар их сульдсаныг анзаарав. Бүх оюун ухааныг давдаг Бурханы амар тайвны тухай Библид гардаг.⁴ Энэ л амар тайван мөргөлийн өрөөг дүүргэн, өрөө дүүрэн дүнгэнэх компьютеруудын гол тэжээлийг хэн нэгэн салгачихсан мэт аниргүй. Ямар ч дуу чимээ гарахгүй байгааг хийгээд Бурханы оршихуй байхгүй болсныг би анзаарлаа.

Бурхантай хамт гүйсэн миний марафон өндөрлөжээ. Босохоор нэг тавилгыг түшин өндийхдөө эхнэр Силвэйн маань хоолны газар хүлээж байгааг санах. Сая юу болоод өнгөрснийг түүнд яаж тайлбарлах билээ? Ойлгох болов уу эсвэл намайг галзуурчихаж гэж бодох болов уу? Мөргөлийн өрөөнөөс юм хумаа аваад гарах гэтэл миний зүүн хөл биеийн жингээ даахгүй догонцов. Унтчихсан юмуу гэлтэй, дугуйгаар удаан явсны дараа хөл мэдээгүй оргиод байдаг шиг хаа нэгтээ мэдээгүй болчихсон мэт санагдан доголсоор хаалгаар гарлаа. Тэгээд тэр өдөржин зүгээр болсонгүй, маргааш нь ч хэвээрээ байсаар арван өдөр доголж явлаа. Түүнээс хойш дөрвөн сарын турш зүүн ташаа маань ийм мэдрэмжтэй байлаа. Сүүлийн хэдэн жил үе үе сэдрэн, ялангуяа JC-2033ын тухай хуваалцахаар аялалаар явах болгонд ингэдэг болсон юм. Зүрхнээс зүрхэнд, биеэс

биед Бурхантай нүүр тулан уулзсан тэр өдрийн санамж гэж би үүнийг ойлгодог юм. Намайг даруусгасан энэ явдал Бурхантай нүүр тулан цөлд уулзахдаа Иаковд тохиолдсон зүйл байсан юм болов уу?⁵

-
1. Хабаккук 2:14
 2. Эхлэл 12:3, 18:18, 22:18
 3. Матай 28:19
 4. Филиппой 4:7
 5. Эхлэл 32:29-30

АМИЛСАН БАЯРЫН МЭНДЧИЛГЭЭ

基督复活了! 真的, 他复活了!

הייחלתל סק אוה, וכא! סק חישמה!

Christ is Risen! Truly, He is Risen!

Χριστός Ανέστη! Αληθώς Ανέστη!

本当に、主はよみがえられたのです!

Christus Resurrexit! Resurrexit vere!

¡Es cierto que el Señor ha resucitado!

Христос Воскресе! Воистину Воскресе!

Le Christ est Ressuscité! Il est vraiment Ressuscité!

Christus ist auferstanden! Er ist wahrhaftig auferstanden!

Hristos a înviat! Adevărat a înviat!

그리스도는 부활! 진실로, 그는 부활!

Cristo è risorto! È veramente risorto!

Христос васкрсе! Ваистину васкрсе!

Kristus nousi kuolleista! Totisesti nousi!

Dassoret eo Krist! E wirionez dassoret eo!

Христос воскресе! Навистина воскресе!

ქრისტე აღსდგა! ჭეშმარიტად აღსდგა!

Chrystus zmartwychwstał! Prawdziwie zmartwychwstał!

Christus isch uferstande! Er isch wahrhaftig uferstande!

БАРАГ 2000 ЖИЛИЙН ӨМНӨ...

Есүс Христийн амилал хүн төрөлхтний хувь заяаг өөрчилсөн билээ. Энэхүү түүхэн тэмдэглэлт ойн баяр ойртож байгаа энэ цаг үед дэлхийн улс, үндэстэн бүр нэгдэн амилсан баярыг асар өргөн уудам тэмдэглэж байгаа үзэгдлийгнэгэн Швейцар залуу хүлээн авсан юм.

Энэ бол түүхэнд хамгийн өргөн тэмдэглэсэн баяр болох нь эргэлзээгүй. ХРИСТ АМИЛСАН! ТЭР ҮНЭХЭЭР АМИЛСАН! гэдэг сайнмэдээг дэлхий даяар сая сая хүн сонсож мэдэх гайхамшигтай боломж.

“Энэ бол маш гайхамшигтай ажил, маш том ажил! Үүнийг хийж байгаад баярлалаа. Хамт алхаж байж эв нэгдэл ирдэг.”

Тэргүүн хамба лам Франсис, Ватикан

Сая сая хүмүүсийн хамтаар дэлхийн түүхэн дэх хамгийн агуу үйл явдал болох Есүсийн амиллыг тэмдэглэхээр нэгдэхийг би дэмжиж, тэсэн ядан хүлээж байна!”

Ники Гамбел, Альфа, UK

“Үндэстэн бүр, Христитгэлийн бүх урсгал чиглэлийн хүмүүстэй хамт тэмдэглэнэ гэдэг үнэхээр мөнхийн улсын амталгаа шүү.”

Ромке Фаунтен, Шуман төв, Нидерланд



ОЛИВЕР ФЛЮРИ бол Швейцарийн Youth With A Mission (YWAM) байгууллагын тэргүүн асан, франц хэлтнүүдийн дунд Альфа курсыг эхлүүлсэн бөгөөд энэхүү гайхалтай үзэгдлийг хүлээн авсан нэгэн.

2033 он болохоос хорь гаруй жилийн өмнө тэрээр “JC2033” хэмээх нэрийн дор энэхүү түүхэн үйл явдлыг дэлхий даяар тэмдэглэх хөдөлгөөнд Христитгэгчдийг уриалан босгох олон улсыг хамарсан санаачлагыг эхлүүлсэн юм. Энэ ном түүний итгэл, найдвар, хайраар дүүрэн, сэтгэл хөдөлгөсөн гэрчлэлийг өгүүлдэг билээ.

